



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/96

Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Засгийн Газрын 2019 оны "Дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоолын 6.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамны Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 гишүүнтэй байхаар тогтоож, яамны албан хаагчдын санал хураалтын дүнг үндэслэн Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Зөвлөлийн даргыг зөвлөлийн хурлаар хэлэлцэж, сонгохыг зөвлөлийн гишүүдэд, Зөвлөлийг нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Зөвлөлийн даргад тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /П.Эрхэмбаяр/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А/117 тушаалыг хүчингүй болгосугай.


ДАРГА



Ц.ЭРДЭМБИЛЭГ

142211253

Төрийн нарийн бичгийн даргын
2021 оны 6 сарын 18-ны өдрийн А/96 дугаар
тушаалын хавсралт



ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|--------------|--|
| Л.Дашравдан | Захиргаа, хуулийн хэлтсийн дарга |
| С.Эрдэнэтуяа | Захиргаа, хуулийн хэлтсийн Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөгөө, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан ахлах шинжээч |
| Л.Мөнхцэцэг | Эрүүл мэндийн салбарын эдийн засгийн бодлого, хэрэгжилтийн газрын Санхүүгийн хэлтсийн Аймгийн эрүүл мэндийн байгууллага болон тусгай зориулалтын төсвийн асуудал хариуцсан шинжээч |
| П.Оюунцэцэг | Судалгаа, төлөвлөлтийн хэлтсийн Засгийн газрын үйл ажиллагаа, үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан шинжээч |
| Д.Баясгалан | Мэдээлэл технологийн хэлтсийн Статистик мэдээллийн боловсруулалт, зохицуулалт хариуцсан шинжээч |